

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/174/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2023 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА Д.БАЯРМАНДАХ ТАНАА

2023.02.24 № 07/401
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн тодотголоор цалин, НДШ, байр ашиглалт, шуудан холбоо, интернэтийн зэрэг нийт 220,660.8 мянган төгрөгийн төсвийг бууруулсан, тодотгосон төсвөөс 4,769.1 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлыг хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант жилийн батлагдсан төсвөөс Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын байрны түрээсийн төлбөрийг төлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 12 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 92.6 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	378,219,621.10	471,356,007.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	3,296,076.30
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	0	3,296,076.30
33	АВЛАГА	360,000,000.00	446,079,019.00
33500	Бусад авлага	360,000,000.00	446,079,019.00
33510	Байгууллагаас авах авлага	120,000,000.00	173,079,019.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	240,000,000.00	273,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,219,621.10	21,980,912.20
35400	Хангамжийн материал	18,219,621.10	21,980,912.20
35410	Бичиг хэргийн материал	345,980.00	223,780.00
35420	Аж ахуйн материал	984,062.00	997,240.60
35430	Сэлбэг хэрэгсэл	9,368,460.00	10,305,930.00
35460	Хүнсний материал	72,300.00	214,840.00
35470	Бусад хангамжийн материал	7,448,819.10	10,239,121.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	32,552,339.97	15,354,395.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	32,552,339.97	15,354,395.97
39200	Биет хөрөнгө	32,552,339.97	15,354,395.97
39203	Авто-тээврийн хэрэгсэл	149,111,940.16	149,111,940.16
39204	Хуримтлагдсан элэгдэл	-141,169,313.54	-145,313,292.86
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	54,080,995.40	54,080,995.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-35,744,281.05	-45,369,609.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,286,364.11	34,286,364.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,013,365.11	-31,442,001.75
39301	Программ хангамж	770,000.00	0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	410,771,961.07	486,710,403.47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	410,771,961.07	486,710,403.47
51	Засгийн газрын хувь оролцоо	410,771,961.07	486,710,403.47
51200	Хуримтлагдсан үр дүн	410,771,961.07	486,710,403.47
51210	Өмнөх үеийн үр дүн	466,415,468.77	410,771,961.07
51220	Тайлант үеийн үр дүн	-55,643,507.70	75,938,442.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	410,771,961.07	486,710,403.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,202,796,356.46	1,617,414,045.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,256.46	35,845.06
120	Нийтлэг татварын бус орлого	32,256.46	35,845.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,256.46	35,845.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,256.46	35,845.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,202,764,100.00	1,617,378,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,202,764,100.00	1,617,378,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,202,764,100.00	1,617,378,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,223,939,864.16	1,582,473,523.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,223,939,864.16	1,582,473,523.27

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,206,630,685.06	1,580,034,456.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	878,634,173.70	1,225,642,535.66
210101	Үндсэн цалин	66,963,700.00	56,724,700.00
210102	Нэмэгдэл	677,705,873.70	1,025,142,635.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	133,964,600.00	143,775,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,743,708.00	20,583,998.85
210201	Тэтгэврийн даатгал	13,863,010.85	12,784,989.87
210202	Тэтгэмжийн даатгал	1,539,210.60	1,664,245.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,214,568.39	1,331,396.27
210204	Ажилгүйдлийн даатгал	284,265.29	312,616.35
210205	Эрүүл мэндийн даатгал	2,842,652.87	4,490,750.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,388,900.00	180,740,668.20
210302	Түлш, халаалт	12,513,700.00	11,423,854.50
210304	Байрны түрээс	160,875,200.00	169,316,813.70
2104	Хангамж, бараа материалын зардал	44,455,814.20	42,251,712.42
210401	Бичиг хэрэг	4,505,000.00	3,043,618.60
210402	Тээвэр, шатахуун	13,326,800.00	20,363,804.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,976,239.20	14,444,886.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	394,000.00	363,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,253,775.00	4,036,102.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,202,800.00	10,568,962.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,400.00	0
210604	Урсгал засвар	6,198,400.00	10,568,962.00
2107	Томилолт, зочны зардал	995,800.00	1,983,049.00
210702	Дотоод албан томилолт	995,800.00	1,983,049.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,093,956.46	79,120,591.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,381,300.00	11,970,555.60
210803	Даатгалын үйлчилгээ	34,958,800.00	54,179,929.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,897,200.00	7,113,485.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	866,600.00	797,050.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,272,000.00	1,519,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,718,056.46	3,539,970.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,115,532.70	19,142,939.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,354,500.00	1,944,995.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,761,032.70	17,197,944.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,309,179.10	2,439,066.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,115,000.00	930,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,115,000.00	930,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,194,179.10	1,508,866.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,194,179.10	1,508,866.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-21,143,507.70	34,940,521.79
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	49,500,000.00
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0	49,500,000.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	34,500,000.00	8,502,079.39
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	34,500,000.00	8,502,079.39
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-55,643,507.70	75,938,442.40

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	466,415,468.77	466,415,468.77

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	466,415,468.77	466,415,468.77
Тайлант үеийн үр дүн	0	0	-55,643,507.70	-55,643,507.70
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	410,771,961.07	410,771,961.07
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	410,771,961.07	410,771,961.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	410,771,961.07	410,771,961.07
Тайлант үеийн үр дүн	0	0	75,938,442.40	75,938,442.40
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	486,710,403.47	486,710,403.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,202,796,356.46	1,617,414,045.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,256.46	35,845.06
120	Нийтлэг татварын бус орлого	32,256.46	35,845.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,256.46	35,845.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,256.46	35,845.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,202,764,100.00	1,617,378,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,202,764,100.00	1,617,378,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,202,764,100.00	1,617,378,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,202,004,356.46	1,605,615,889.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,202,004,356.46	1,605,615,889.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,184,695,177.36	1,603,176,822.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	878,634,173.70	1,225,642,535.66
210101	Үндсэн цалин	66,963,700.00	56,724,700.00
210102	Нэмэгдэл	677,705,873.70	1,025,142,635.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	133,964,600.00	143,775,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,743,708.00	20,583,998.85
210201	Тэтгэврийн даатгал	10,349,100.00	12,784,989.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,256,400.00	1,664,245.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,386,908.00	1,331,396.27
210204	Ажилгүйдлийн даатгал	1,651,300.00	312,616.35
210205	Эрүүл мэндийн даатгал	2,100,000.00	4,490,750.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,388,900.00	217,319,687.20
210302	Түлш, халаалт	12,513,700.00	11,423,854.50
210304	Байрны түрээс	160,875,200.00	205,895,832.70
2104	Хангамж, бараа материалын зардал	48,281,339.20	43,126,333.52
210401	Бичиг хэрэг	4,589,200.00	2,921,418.60
210402	Тээвэр, шатахуун	13,326,800.00	20,363,804.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,976,239.20	14,444,886.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	513,500.00	243,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,875,600.00	5,152,423.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,202,800.00	13,455,632.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,400.00	2,886,670.00
210604	Урсгал засвар	6,198,400.00	10,568,962.00
2107	Томилолт, зочны зардал	995,800.00	1,983,049.00
210702	Дотоод албан томилолт	995,800.00	1,983,049.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,093,956.46	79,120,591.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,381,300.00	11,970,555.60
210803	Даатгалын үйлчилгээ	34,958,800.00	54,179,929.80

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,897,200.00	7,113,485.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	866,600.00	797,050.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,272,000.00	1,519,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,718,056.46	3,539,970.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,354,500.00	1,944,995.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,354,500.00	1,944,995.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,309,179.10	2,439,066.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,115,000.00	930,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,115,000.00	930,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,194,179.10	1,508,866.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,194,179.10	1,508,866.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	792,000.00	11,798,155.69
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	792,000.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	792,000.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	792,000.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	792,000.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-792,000.00	0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-8,502,079.39
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0	8,502,079.39
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0	8,502,079.39
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	3,296,076.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	3,296,076.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,617,378,200.00	1,604,107,022.97	13,271,177.03	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,617,378,200.00	1,604,107,022.97	13,271,177.03	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,616,341,300.00	1,603,176,822.97	13,164,477.03	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,225,843,400.00	1,225,642,535.66	200,864.34	100.0
210101	Үндсэн цалин	56,724,700.00	56,724,700.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл	1,025,343,500.00	1,025,142,635.66	200,864.34	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	143,775,200.00	143,775,200.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,810,400.00	20,583,998.85	2,226,401.15	90.2
210201	Тэтгэврийн даатгал	12,900,000.00	12,784,989.87	115,010.13	99.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,500,000.00	1,664,245.55	835,754.45	66.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,000,000.00	1,331,396.27	668,603.73	66.6
210204	Ажилгүйдлийн даатгал	600,000.00	312,616.35	287,383.65	52.1
210205	Эрүүл мэндийн даатгал	4,810,400.00	4,490,750.81	319,649.19	93.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	218,231,900.00	217,319,687.20	912,212.80	99.6
210302	Түлш, халаалт	12,109,600.00	11,423,854.50	685,745.50	94.3
210304	Байрны түрээс	206,122,300.00	205,895,832.70	226,467.30	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	46,648,800.00	43,126,333.52	3,522,466.48	92.4
210401	Бичиг хэрэг	2,924,000.00	2,921,418.60	2,581.40	99.9
210402	Тээвэр, шатахуун	20,404,000.00	20,363,804.72	40,195.28	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,365,000.00	14,444,886.30	1,920,113.70	88.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	744,500.00	243,800.00	500,700.00	32.7

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,211,300.00	5,152,423.90	1,058,876.10	83.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,541,700.00	13,455,632.00	86,068.00	99.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,897,800.00	2,886,670.00	11,130.00	99.6
210604	Урсгал засвар	10,643,900.00	10,568,962.00	74,938.00	99.3
2107	Томилолт, зочны зардал	1,998,100.00	1,983,049.00	15,051.00	99.2
210702	Дотоод албан томилолт	1,998,100.00	1,983,049.00	15,051.00	99.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,055,900.00	79,120,591.34	935,308.66	98.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,988,900.00	11,970,555.60	18,344.40	99.8
210803	Даатгалын үйлчилгээ	54,186,000.00	54,179,929.80	6,070.20	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,138,200.00	7,113,485.00	24,715.00	99.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	802,800.00	797,050.00	5,750.00	99.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,589,400.00	1,519,600.00	69,800.00	95.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,350,600.00	3,539,970.94	810,629.06	81.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,211,100.00	1,944,995.40	5,266,104.60	27.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,211,100.00	1,944,995.40	5,266,104.60	27.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,036,900.00	930,200.00	106,700.00	89.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,036,900.00	930,200.00	106,700.00	89.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,036,900.00	930,200.00	106,700.00	89.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,617,378,200.00	1,615,905,178.66	1,473,021.34	99.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,617,378,200.00	1,615,869,333.60	1,508,866.40	99.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,617,378,200.00	1,615,869,333.60	1,508,866.40	99.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	35,845.06	-35,845.06	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	35,845.06	-35,845.06	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	3,296,076.30	-3,296,076.30	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	13	13	0.00	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	6	6	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	0	0	0.00	-
620004	Гэрээт ажилтан	0	0	0.00	-

Гурав. Аудитын илрүүлэлт

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 46,600.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 10,436.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 7,763.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,673.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 10,436.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон 18,559.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Жилийн эцэст гадаад валютын ханшийн тэгшитгэлийг данс буруу ангилан бүртгэж урсгал зардлаар бүртгэсэн.	1	8,502.1			1	8,502.1	1	8,502.1				
Мөнгөн хөрөнгийн данснаас ажил, гүйлгээг тооцооны дансанд бүртгэлгүйгээр шууд зардалд бүртгэсэн.	1	1,519.6			1	1,519.6	1	1,519.6				
БНСУ дахь НХТ-ийн Нийгмийн даатгалын албаны түрээсийн төлбөр төлснийг тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй.	1	36,579.0			1	36,579.0	1	36,579.0				
Дүн	3	46,600.7			1	46,600.7	3	46,600.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жилийн эцэст арилжааны банк дахь харилцах дансны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн сангийн бүртгэлийн дансанд	1	3,296.1	1	3,296.1								

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

төвлөрүүлсэн 3.3 сая төгрөгийн гүйлгээ нь он дамжин замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан ба, тус үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.												
Төсвийн зардлыг бүлэг хооронд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй 2.7 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан.	1	2,673.9					1	2,673.9				
2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг өмнөх оны мэдээлэлтэй зэрэгцүүлэн тайлагнаагүй, Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байна.	1	-					1	-				
БНСУ-ын КТ телеком үүрэн холбооны сүлжээний 010-9925-0540 дугаар нь тус төвийн даргын нэр бүртгэлтэй бөгөөд ярианы төлбөрт 2022 онд 1,857,230.00 вон буюу 4,466,898.00 төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн байна.	1	4,466.9	1	4,466.9								
Дүн	4	10,436.9	2	7,763.0			2	2,673.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Шилэн дансны нэгдсэн цахим системд 149 мэдээлэл оруулахаар 3 мэдээллийг хугацаа хоцроож, байгууллагын батлагдсан төсөв, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 гэрээний 202.1 сая төгрөгийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн мэдээллийг мэдээлээгүй.	1	202,089.4					1	202,089.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин урсгал төсвийн зардлаас сургалт, семинарыг танхимаар зохион байгуулж 1.9 сая төгрөгийн зардал гаргасан.	1	1,945.0				1	1,945.0	
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээгүй байна.	1	-					1	-
Тайлант оны 4-р сард төвийн дарга Д.Баярмандахад 13,400.0 мянган Солонгос вонын урьдчилгаа цалин олгосон нь Хөдөлмөрийн дотоод журамд заасан дээд хязгаараас 6,400.0 мянган Солонгос воноор илүү дүнгээр олгосон байна.	1	15,808.0				1	15,808.0	
Нийт дүн	4	219,842.4				2	17,753.0	202,089.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 08 дугаар сарын 24 № 82/У-160005
СНУГ - 2023/31/14 - СНУ - 1005

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст Төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлсэн арилжааны банкны харилцах данс дахь төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 3,296,076.30 төгрөгийг он дамжин замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан ба тус үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант оны төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 3,296,076.30 төгрөгийг Төрийн сан дахь 100900080014 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга Д.Баярмандах, санхүү, нягтлан бодох, тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн Я.Гармаа нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ч.БОЛД

АХЛАХ АУДИТОР

С.БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 дугаар сарын 21

№ 121 / АО160065

Улаанбаатар хот

СНАГ - 2023/174/МА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

БНСУ-ын КТ телеком үүрэн холбооны сүлжээний 010-9925-0540 дугаар нь тус төвийн даргын нэр дээр бүртгэлтэй бөгөөд гар утасны ярианы төлбөрт 1,857,230.00 вон буюу 4,466,898.00 төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1 "гар утасны зардал", Монгол Улсын Их Хурлын "Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 2016 оны 47 дугаар тогтоолын 2В-ийн 2-д 2/албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх", "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.1 "Төв нь иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгөх 4 лавлах утастай байна" /02-2278-8030, 02-2278-8034, 02-2266-8228, 02-2266-9229/ заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гар утасны ярианы төлбөрт төлсөн 4,466,898.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга Д.Баярмандах, санхүү, нягтлан бодох, тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн Я.Гармаа нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Mkn\2023\0315 SNAG-21.Docx

0001790069



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 21 № 288/410005
СНУГ - 0023/01/14 - СА - 7118

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд урсгал төсвийн зардлаас сургалт, семинарыг танхимаар зохион байгуулж 1,944,995.40 төгрөгийн зардал гаргасан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, сургалтыг цахимаар зохион байгуулж байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга Д.Баярмандах, санхүү, нягтлан бодох, тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн Я.Гермаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Ч.БОЛД

С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2023\0224\SNAG-132.Docx

0001080576



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21

№ 437/А0160065

Улаанбаатар хот

СНАГ - 2023/174/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 4 дүгээр сард төвийн дарга Д.Баярмандахад 13,400,000.00 воны урьдчилгаа цалин олгосон нь Хөдөлмөрийн дотоод журамд заасан дээд хязгаараас 6,400,000.00 вон буюу 15,808,000.00 төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь БНСУ дахь ХНХҮТ-ийн даргын 2019 оны А/36 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.2.6-д "Ажилтны бичгээр гаргасан хүсэлтийн дагуу 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний урьдчилгаа цалинг төвийн даргын зөвшөөрлөөр олгож болно" заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөдөлмөрийн дотоод журамд заасан урьдчилгаа цалин олгох дээд хязгаарыг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга Д.Баярмандах, санхүү, нягтлан бодох, тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн Я.Гармаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Ч.БОЛД

С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг-1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

Z:\Alban Shaardlaga\2023\0315 SNAG-33.Docx

0001080972